



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 0/22

Мандалговь

Г Захирамжинд өөрчлөлт оруулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 "г", 29.1.5 "а" дахь заалтууд, Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 1994 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 107 дугаар захирамжийн 3 дахь заалтад заасан 2 өрөө байрыг аймгийн Залуучуудын холбоонд үнэ төлбөргүй эзэмшүүлсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Хоёр. Залуучуудын холбоонд эзэмшүүлсэн 2 өрөөг 2017 оны 01 дүгээр сарын 24-ны дотор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй өөрчлөн байгуулсугай. Үүнд:

Комиссийн дарга:	Ц.Эрдэнэсүрэн	-АЗДТГ-ын НБХ-ийн дарга
Гишүүд:	Э.Чагнаадорж	-ГХБХБГ-ын дарга
	С.Ууганбаяр	-Орон нутгийн өмчийн албаны даргын үүрэг гүйцэтгэгч
	Ц.Мөнхбат	-Залуучуудын холбооны тэргүүн
	Т.Уранбайгаль	-АЗДТГ-ын ХЭЗХ-ийн мэргэжилтэн

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/442 тоот захирамжийн 3, 4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА О. БАТ-ЭРДЭНЭ

000000036